



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 18 өдөр

Дугаар A/132

Улаанбаатар хот

Газар эзэмших эрх дуусгавар
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/451 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрх дуусгавар болгох хүсэлт ирүүлсэн 2 (Хоёр) иргэний газар эзэмших эрхийг хавсралтад зааснаар дуусгавар болгосугай.

2. Газар эзэмших эрх нь дуусгавар болж байгаа иргэдтэй холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариу мэдэгдэж хэрэгжилтэд нь хяналт тавьж, ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/244 дүгээр захирамжийн Г.Дагвадорж, 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/117 дугаар захирамжийн Х.Маралмаа нарт хамаарах хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД